

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН АЛБА



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН /төслөөр/

“Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний
хэрэгжилт, үр дүн”-д
хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ӨВА-2020/05/-ГА

Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газрын
Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Палаачин
Утас: 70323253, Цахим хаяг: lamaachinl@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833, Цахим хаяг: gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Чимэдцэрэн
Утас: 70323833, Цахим хаяг: chimedtserenb@audit.gov.mn

Аудитор: С.Шилэгмаа
Утас: 70323833, Цахим хаяг: shilegmaab@audit.gov.mn

Аудитор: П.Норпил
Утас: 70323833, Цахим хаяг: norpiir@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
Дараах хаягаар зөна уу. Цахим хуудас: www.audit.gov.mn

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор (Л.Ламаачин)</p> <p>Аудитын менежер (Д.Гансүх)</p> <p>Ахлах аудитор (Б.Чимэдцэрэн)</p> <p>Аудитор (С.Шийлэгмаа) (П.Норпил)</p> <p>Гэрээт аудитор (Ж.Нямаа)</p> <p>2020 оны 6 дүгээр сар</p> <p>Уг тайланг www.audit.mn хаягаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323833 дугаарын утас, 70323253 дугаарын факсаар харилцана уу</p> <p>ХАЯГ:</p> <p>(Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 405 тоот)</p>	<p>Товчилсон үгийн тайлбар2-3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-12</p> <p>БүлэгА Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдээгүй, зарим ХАА хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх нь тодорхойгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 27.2 хувийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан төлөвлөөгүй байна. ✓ Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. ✓ Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. ✓ Ихэнх тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна. ✓ Зарим гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх нь тодорхой бус байна. <p>Б. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүн хангалтгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Гэрээт хугацаанд хүлээлгэн өгсөн зарим ажлын чанар хангалтгүй байна. ✓ Захиалагч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна. ✓ Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. ✓ Зарим хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. ✓ Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна <p>Дүгнэлт</p> <p>Зөвлөмж</p> <p>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал</p> <p>Саналд өгсөн тайлбар</p> <p>Хавсралтууд</p>
---	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТББ	Тендерийн баримт бичиг
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТОӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ААН	Аж ахуйн нэгж
м	метр
у/м	урт метр
БНБД	Барилгын норм ба дүрэм

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан ӨВА-2020/05-ГА кодтой төлөвлөгөөний дагуу "Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт үндэслэлтэй хийгдэж, ХАА хууль журмын дагуу зохион байгуулагдсан эсэх
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитын хамрах хүрээ:

Энэхүү аудитыг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Өлзийт, Тарагт, Хархорин зэрэг сумд, ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ зэрэг байгууллагыг хамруулан тэдгээрийн эрх зүйн үндэслэл, гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ, хөрөнгө оруулалтын үр дүн, хэрэгжилтийн талаарх тайлан, судалгаа, мэдээлэлд үндэслэн бодит байдлыг газар дээр нь үзэж, холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ: Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ-ийн мэргэжилтнүүд, аймаг, сумдын удирдлага болон бусад ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой хууль, эрх зүйн байдлыг бодит байдалтай харьцуулах, мэдээ, судалгаа, ажлын тайланд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг баримталсан бөгөөд аудитын хөтөлбөр болон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулах ажиллагаа хийгдэв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Барилгын тухай хууль
- ✓ Иргэний хууль
- ✓ Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргын Захирамж, бусад эрхийн актууд
- ✓ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"
- ✓ Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"
- ✓ Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн актууд

Аудитын стандартын талаарх мэдээдэл:

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ: Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гаргасан Өвөрхангай аймаг дахь Төрийн газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан ӨВА-2020/04-ГА кодтой аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав. Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын ахлах аудитор Б.Чимэдцэрэн, аудитор С.Шийлэгмаа, П.Норпил нар 2020 оны 5 дугаар сарын 11-ээс 6 дугаар сарын 26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аудитаар 445.2 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 445.2 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 7 зөвлөмж өгөв.

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019 ОНЫ ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

А. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдээгүй, зарим ХАА хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх нь тодорхойгүй байна.

А.1. Хууль, журамд заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулаагүй байна.

А.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 27.2 хувийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан төлөвлөөгүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2016 оны 2/01 тогтоолоор, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 09/02 тогтоолоор баталжээ. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжих хөрөнгө оруулалтад 35 төсөл, арга хэмжээнд 2 тэрбум 638 сая 991.5 мянган төгрөг баталсан байна. Үүнээс 17 төсөл арга хэмжээ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасдаагүй байгаа нь нийт төлөвлөсөн санхүүжилтийн 27.2 хувийг эзэлж байна. Үүнд:

- Махны үйлдвэрийг худалдан авсны үнийн зөрүү 26.8 сая төгрөг,
- Аймгийн танилцуулга, альбом хэвлэх дурсгалын зүйл хийлгэх зардал 50.0 сая төгрөг,
- Аймгийн ЗДТГ-ын барилгын гадна засварын ажил 270.0 сая төгрөг,
- Орон сууц худалдан авах зардал 34.0 сая төгрөг,
- Хархорин суманд төрийн үйлчилгээний авто машин 40.0 сая төгрөг,
- Авто замын засвар арчилгаа, нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээ, бродюр шохойдох, гэрлэн дохионы шинэчлэл 73.8 сая төгрөг,
- Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн тухай баримтат кино хийх зардал 20.0 сая төгрөг,
- Гэгээнтний сургалтын зардал 15.0 сая төгрөг,
- Арвайхээр суманд шинээр баригдах авто замд шаардагдах газар чөлөөлөх арга хэмжээний зардал 30.0 сая төгрөг,
- Багуудын өдөрлөгийн арга хэмжээний зардал 20.0 сая төгрөг,
- Монгол Улсын начин цолтонд 15.0 сая төгрөг,
- Улсын арслангийн хөшөө босгох зардал 5.5 сая төгрөг,
- Ц.Гайтавын мэндэлсний 90 жилийн ойн арга хэмжээний зардал 12.6 сая төгрөг,
- Цанын баазын зураг төсвийн зардал 40.0 сая төгрөг,
- Төрийн албан хаагчийн эмчилгээний зардал 10.0 сая төгрөг,

- Өлзийт сумын нийтийн орон сууцыг шугам сүлжээний зардал 5.0 сая төгрөг,
- Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Н.Жанцанноровт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардал 50.0 сая төгрөг байна.

А.1.2. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус дараах төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. Үүнд:

- Эвент арга хэмжээний зардалд 60.0 сая төгрөг,
- Аймгийн танилцуулга, альбом хэвлэх дурсгалын зүйл хийлгэх зардалд 50.0 сая төгрөг,
- Гандан пунцоглин хийдийн гэгээнтний сургалтын зардалд 15.0 сая төгрөг,
- Сумдын ахмадын байгууллагын урамшуулалд 10.9 сая төгрөг,
- Багуудын өдөрлөгийн арга хэмжээний зардалд 20.0 сая төгрөг,
- Монгол Улсын начин цолтонд 15.0 сая төгрөг,
- Ц.Гайтавын мэндэлсний 90 жилийн ойн арга хэмжээний зардалд 12.6 сая төгрөг,
- Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Н.Жанцанноровт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардалд 50 сая төгрөг тус тус баталж, зарцуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 2019 онд 2 тэрбум 638 сая 991.5 мянган төгрөг баталж, 2 тэрбум 596 сая 379.0 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнийг графикаар харуулбал:



Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь Сангийн сайдын 2016 оны 415 тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 3 дахь хэсгийн 3.6-д "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна" гэж заасны дагуу хэрэгцээ, шаардлагаар нь эрэмбэлээгүй байна.



А.1.3. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь Сангийн сайдын 2016 оны 415 тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 3 дахь хэсгийн 3.6-д "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна" гэж заасны дагуу хэрэгцээ, шаардлагаар нь эрэмбэлээгүй байна. Иймд аймгийн ИТХ-ын тогтоолоор тооцоо судалгаагүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээ баталж, дараагийн тогтоолоор өмнө баталснаа байнга өөрчлөгдсөн байна. Тухайлбал:

Аймгийн 2019 оны төсөв батлах тухай 09/10 дугаар тогтоолоор 11 төсөл, арга хэмжээнд 2,291.5 сая төгрөг баталсан боловч оны дундуур тодотгол хийсээр дээрх төсөл арга хэмжээний 716.8 сая төгрөгийн 5 нь хэрэгжиж бусад нь хасагдсан байна.

А.2. Зарим худалдан авах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх нь тодорхойгүй байна.

А.2.1. Ихэнх тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна.

Ихэнх тендерийн баримт бичгийг хуулийн 19 дүгээр зүйл болон Сангийн сайдын тушаалаар батлагдсан Тендерийн жишиг баримт бичгийн дагуу боловсруулжээ. Гэхдээ Арвайхээр суманд нэг өрөө байр худалдан авах ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичигт дараах зөрчил байна. Тухайлбал:

- Тендерийн баримт бичгийг боловсруулах, техникийн тодорхойлолтыг бэлдэхдээ үнэлгээний хороо хуралдаагүй,
- Худалдан авах байрны талбайн хэмжээ, барилгын хийц, тоноглол зэргийг тусгаагүй байна.

А.2.2. Зарим гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохирн байгуулагдсан эсэх нь тодорхой бус байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийн тендер шалгаруулалтад тус бүр нэг, нэг аж ахуйн нэгж оролцож шалгарсан байна. Үүнд:

- ✓ Хүүхэд хамгаалах байр барих тендерт Гүнчимэгтэй ХХК,
- ✓ Нэг өрөө байр худалдан авах тендерт Хангамж-Өргөө ХХК,
- ✓ Нийтийн эзэмшлийн талбайд мод бут, сөөг тарих ажлын тендерт Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ,
- ✓ Нийтийн эзэмшлийн талбайд олон наст хуйлдаг зүлэг тарих, хөрс бэлтгэх ажлын тендерт Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ,
- ✓ Нийтийн эзэмшлийн талбайд олон наст таримал зүлэг тарих ажлын тендерт Свебау хаус ХХК,
- ✓ Арвайхээр суманд өөрөө буулгагч самосвал машин нийлүүлэх тендерт "Арвайхээр ТҮК" ОНӨААТҮГ,
- ✓ Арвайхээр, Хархорин сумдад хийгдэх 1040 метр хайсан хашаа хийх ажлын тендерт "Болор Өрөг" ХХК,
- ✓ Багш хөгжлийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт Сүү хүнгий ХХК тус бүр ганцаараа оролцож шалгарсан байна.



4. Нийтийн эзэмшлийн 20.0 мянган м² талбайд олон наст таримал зүлэг тарих ажлыг Свебау хаус ХХК 98.7 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Наадмын талбай, Арвайхээр палас зочид буудлын урд талбай, 8 дугаар цэцэрлэгийн урд хэсэг, баруун дөрвөн замын гэрлэн дохионы дугуй тойрог, Арвайхээр сумын ЗДТГ-ын гадаа талбайг тус тус зүлэгжүүлж, тайлант онд ургалт сайн байжээ. Гэвч нэг наст зүлэг тарьсан учраас 2020 онд дээрх зүлэгжүүлсэн газруудад ногоо огт ургахгүй байгаагаас харахад 98.7 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ажил үр дүнгүй болсон байна.

Б.1.2. Захиалагч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 2019 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах, засварлагдах барилга болгонд бүх шатны ил, далд ажилд мэргэжлийн заавар, зөвлөгөөг өгч ажилласан байна.

Б.2. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч санхүүжилтээ бүрэн авсан тохиолдол байна.

Б.2.1. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан мэргэжилтнүүд барилга угсралтын ажлын явцад үе шатны хяналтуудыг хийж, ажлын талбай хариуцсан инженер, даамлуудад үүрэг даалгавар, заавар, зөвлөмжийг өгч, тухай бүр гэрэл зургаар баталгаажуулж, ажлын журналд тэмдэглэл үйлдэж, дараагийн үе шатны хяналт хийхдээ өмнөх үүрэг даалгаврын биелэлтийн байдал, барилгын норм, дүрэм, стандарт, барилгын чанар байдлыг хангуулан ажиллаж ирсэн нь хяналт үр дүнтэй болсон гэж үзэж байна.

Б.2.2. Зарим хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

Ажлын гүйцэтгэлийг холбогдох албан тушаалтнуудаар батлуулж, гүйцэтгэлийг зураг, актаар баталгаажуулан нэхэмжлэлийг үндэслэн санхүүжилт олгож иржээ.

Спорт ордны бэлтгэлийн заалны барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн Навтгар хайрхан ХХК-д барилгын гадна талбайн ажлыг хийгээгүй байхад, ажлын гүйцэтгэл гаргаж 199.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон төсөл, арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгажээ.

Б.2.3. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

Гэрээний хариуцлагын хэсэгт тусгагдсан барилга угсралт, засварын ажлыг гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хүртэлх хувиар алданги ногдуулахаар, зарим ажил гүйцэтгэх гэрээнд ашиглалтад оруулах хугацааг хэтрүүлсэн тохиолдолд үнийн дүнгийн 0.01 хувьтай тэнцэх торгуулийг хоцорсон хоног тутамд төлөхөөр гэж заасан боловч хэрэгжихгүй байна.

ДУГНЭЛТ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019 ОНЫ ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

А. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдээгүй, зарим ХАА хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх нь тодорхойгүй байна.



- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 27.2 хувийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан төлөвлөөгүй байна.
- ✓ Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.
- ✓ Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.
- ✓ Ихэнх тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна.
- ✓ Зарим гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх нь тодорхой бус байна.

Б. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүн хангалтгүй байна.

- ✓ ✓Гэрээт хугацаанд хүлээлгэн өгсөн зарим ажлын чанар хангалтгүй байна.
- ✓ Захиалагч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.
- ✓ Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.
- ✓ Зарим хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.
- ✓ Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, Засаг дарга Г.Ганболд нарт:

1. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгаж байх
2. Сангийн сайдын 2016 оны 415 тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 3 дахь хэсгийн 3.6-д заасны дагуу эрэмбэлсэн ТАХ-г төлөвлөж, санхүүжүүлж байх
3. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж төлөвлөхгүй байх
4. Аймгийн ИТХ-ын тогтоолоор тооцоо судалгаагүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээ баталж, дараагийн тогтоолоор өмнө баталснаа байнга өөрчлөхгүй байх

Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга Н.Ганболд, ХАА-ны албаны дарга Б.Даваасүрэн нарт:

5. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байх

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Г.Баясгалан

6. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг хууль, журам, стандартын дагуу боловсруулж байх

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Г.Баясгалан, СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр, Засаг даргын дэргэдэх ГХБХБГ-ын дарга Ч.Гүнсэнхорол нарт:

7. Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нарт хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцож холбогдох арга хэмжээ авч байх

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР